

Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, шим тэжээлийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Дондог Оюун-Эрдэнэ

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Хүүхдийн хоолны шим тэжээл, чанар хүртээмжийг сайжруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох							
1	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна.	Хуулийн төсөл	Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үзэл баримтлалын төслийн судалгаа	Хуулийн төслийн судалгаа хийж, үзэл баримтлалын төсөл батлуулан, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлсэн байна.	1. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалыг Боловсролын сайд, Хүнс хөдөө аж ахуйн сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд хамтран баталсан. Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалд сургуулийн хоол хүнсний хангамжид чанар аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний түүхий эд бүтээгдэхүүний тогтвортой ханган нийүүлэхэд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг тодорхой болгох, нэг хүүхдийн хоолны үйлчилгээний бүрэн өртөгийг тооцон (хувьсах зардлаар) санхүүжүүлэх, орон нутгийн бие даасан байдлыг хангах, хяналт үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх зэрэг өөрчлөлтүүдийг оруулахаар тусгасан болно. Хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг Боловсролын сайдын 2025 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн А/126 дугаар баталсан. 2. ЕБС-ийн хоол үйлдвэрлэлийн үйлчилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Хууль	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал:

					тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох барим бичгийн төслийг бусдаар гүйцэтгүүлэх "Зардал батлах тухай" Сайдын 2025.04.11-ний өдрийн А/155 тушаалыг батлуулав. 3. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоол хүнсний үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хоол шим тэжээлийн боловсрол олгох, хууль эрх зүйн орчны шинэчлэл, санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхэд талуудын оролцоо, санал шийдлийг гаргаж, хэрэгжүүлэх зорилгоор "Хүүхдийн хоол " хэлэлцүүлгийг 2025.05.20-ны өдөр Чингис хаан Үндэсний музейд зохион байгуулав. Тус арга хэмжээнд УИХ-ын гишүүн, ЕТГ, ТЗТБ болон ЕБС-ын тогооч, хоолзүйч нарын нийт 75 төлөөлөл оролцож салбарын өнөөгийн байдал тулгамдаж буй асуудлыг хүрээнд санал солилцов. 4. Хуульд нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалыг танилцуулан, хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх, санал солилцох уулзалтыг 2025.06.06-ны өдөр цахим болон танхимаар зохион байгуулав. Тус уулзалт хэлэлцүүлэгт нийслэлийн ЕБС-ын удирдлага, хоол зүйч, тогооч 60 хүн, цахимаар орон нутгийн БГ, ХХААГ, ЭМГ-ын төлөөлөл оролцож санал солилцов. Хавсралт: 10 файл		100%
2	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжсэн төлөвлөгөөг батлуулна.	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын 2020 оны 207, 2021 оны 18 дугаар тогтоол	Засгийн газрын 2020 оны 207, 2021 оны 18 дугаар тогтоолын хэрэгжилтэд үнэлгээ хийнэ	1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүнсний хангамжийг сайжруулах ажлын хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилд хэрэглэх хүнсний хангамжийн тооцоо, судалгааг аймаг, бүсийн хэмжээнд шинэчлэн гаргав. Тус хичээлийн жилд 1,057,324 суралцагчийн хүнсний түүхий эдийн хангамжид мах, махан бүтээгдэхүүн 12.6 мян. н, сүү, сүүн бүтээгдэхүүн 25.9 мян тн, гурил, гурилан бүтээгдэхүүн 17.9 мян тн, төрөл бүрийн будаа 6.2 мян тн, төмс, хүнсний ногоо 27.0 мян тн, жимс, жимсгэнэ 17.3 мян тн тус тус хэрэглэхээр байна. 2. Засгийн газрын 2020 оны 207, 2021 оны 18 дугаар тогтоолын хэрэгжилтэд үнэлгээ хийх хүрээн ХХААХҮЯ, аймгийн	3-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ

					Боловсролын газраас хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг авч ХШҮДАГ-т хүргүүлэв. Хавсралт: 1 файл		төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
1.2. Шим тэжээлийн хэмжээг хангахуйц, тэгш хүртээмжтэй хоол, хүнсний үйлчилгээг нэвтрүүлэх							
3	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийг үдийн сүүгээр хангах "Өдөр бүр нэг аяга сүү" хөтөлбөрийг хэрэгжүүлнэх	1. 2024 оны хэрэгжилтийн судалгаа 2. Засгийн газрын тогтоол 3. Хөтөлбөрт хамрагдсан суралцагчийн эзлэх хувь	1. - 2. - 3. 5 хувь	1. 1 2. - 3. -	1. "Өдөр бүр нэг аяга сүү" хөтөлбөрийн хүрээнд 2024 онд сүү хөтөлбөр хэрэгжүүлсэн аймаг, орон нутгийн тайлан судалгааг гаргав. 2024 онд Улаанбаатар, Говьсүмбэр, Завхан, Дорноговь, Орхон, Өвөрхангай, Төв, Ховд, Хэнтий аймгийн нийт 227 цэцэрлэг, сургуулийн 81,964 суралцагч орон нутгийн төсөв болон эцэг, эх, асран хамгаалагч, төсөл хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр 120-250 мл хэмжээтэй сүүг 7 хоногийн 1-5 өдөр нэмэлтээр өгсөн байна. 2025 онд "Өдөр бүр нэг аяга сүү" хөтөлбөрийг нийслэл болон 12 аймаг /Говь-Алтай, Говьсүмбэр, Завхан, Дорноговь, Дундговь, Орхон, Өвөрхангай, Төв, Хэнтий, Баянхонгор, Дорнод, Дархан-Уул/-ийн 241 цэцэрлэг, сургуулийн 85,262 суралцагч хамрагдаж байна. 2. Хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх салбар дундын оролцоог хангах зорилгоор Боловсролын сайдын А/93 дугаар тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлуулав. Тус ажлын хэсэгт ЕТГ, ЭЗХЯ, ЭМЯ, ХХААХҮЯ, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ийн ХХААБ болон холбогдох төлөөлөл орсон. Тус ажлын хэсгийн анхны хурлыг 4 сард зохион байгуулсан бөгөөд хурлаар Сүү хөтөлбөрийг хэрэгжүүлж буй олон улсын туршлага, Монгол улсын хөтөлбөрийн хэрэгжилт, өнөөгийн байдал, МУ-ын сүүний хангамжийн өнөөгийн нөхцөл байдал зэрэг салбар дундын мэдээлэл солилцож, гишүүдэд хөтөлбөрийг 2025-2028 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг танилцуулж, санал солилцов. 3. Боловсролын сайдын "Арга хэмжээ зохион байгуулах, зардал батлах тухай" 2025 оны А/246	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					дугаар тушаалаар "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч нарт Монголын 5 өнгийн идээ ундааг ашиглан түүх соёл, өв уламжлал, ёс заншлыг таниулах "Уламжлалт сүү, цагаан идээ боловсруулах өдөрлөг"-ийг Лосолын лааган хүүхдийн хөгжил НҮТББ-тай хамтран 2025.05.30-ны өдөр зохион байгуулав. Хавсралт: 10 файл		
4	Хоол тэжээлийн тусгай хэрэгцээт хүүхдүүдэд зориулсан тохируулгат арга хэмжээг хэрэгжүүлнэ	1. Аргачлалын дагуу үнэлгээ хийх 2. Хоолны цэс гаргаж туршсан байна	Үнэлгээний аргачлал, хоолны жор технологи	Зорилтод 45 сургууль /тусгай2 цэцэрлэг/-д хоол тэжээлийн тусгай хэрэгцээт хүүхдийг үнэлж, хоолны цэсийг туршилт эхэлсэн байна.	1. Хоол тэжээлийн тусгай хэрэгцээт суралцагчдад зориулсан хооллох хэрэглэгдэхүүний судалгааг нийслэлийн ЕБ-ын тусгай 25, 55, 63, 70-р сургуулиудаас авч удирдлагад танилцуулан "Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл"-д хүргүүлэв. 2. Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн 2-р бүрэлдэхүүний хүрээнд "Хоол тэжээлийн тусгай хэрэгцээт хүүхдийн хооллолтод дэмжлэг үзүүлэх аргачлалыг боловсруулан, цэцэрлэг, сургуульд зориулан хэвлүүлсэн. уг гарын авлагад орсон бэрхшээлийн онцлог ялгаа, гарын авлагыг хэрхэн ашиглах, хэн хэн ямар үүрэгтэй оролцох талаар 13 теле хичээл бэлтгэн MEDLE.MN-ний теле хичээл-Эрүүл мэнд, зөв хооллолт буланд байршуулж, түүнийг гарын авлагад QR код болгон байршуулснаар эцэг эх асран хамгаалагч, багш ажилчид ашиглахад хялбар болгосон. https://www.medle.mn/telelesson/99/500/100004931963858/99 Хавсралт: 1 файл	1-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 9-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
5	Цэцэрлэг сургуулийн хүнсний хангамжид орон нутгийн хүнсний нийлүүлэлтийг	1. Хоолны түүхий эдийг цахим дэлгүүрээс худалдан авдаг цэцэрлэг, сургуулийн	1. 10 хувь 2. Дархан Уул аймагт ерөнхий гэрээний аргыг нэвтрүүлсэн .	1.15 хувь 2. -	1. МУ-ын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Худалдан авах ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал хүргүүлэх тухай хуулийн төсөлд дараах саналыг боловсруулан СХОГ-т хүргүүлэв. Үүнд: а. Хуулийн төслийн 8.1-т "... хангах боломжтой чанар, стандартын шаардлага хангасан ..., " гэснийг "... хангах боломжтой тохирлын баталгаатай чанар, стандартын шаардлага хангасан	1-р сар, 3-р сар, 6-р сар, 8-р сар, 10-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ:

	нэмэгдүүлэх, худалдан авалтыг оновчтой зохион байгуулалтын сүлжээ бий болгох	эзлэх хувь 2. Ерөнхий гэрээгээр худалдан авах үйл ажиллагааг орон нутагт нэвтрүүлэх			...” гэж өөрчлөх; б. Төслийн 8.4-т шинээр “8.4.6.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хоол хүнсний хангамжид тухайн бүс орон нутагт үйлдвэрлэсэн тохирлын баталгаатай, чанар стандартын шаардлага хангасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх” гэж нэмэх; в. Хуулийн төслийн 36.1.16-т “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоол, хүнсний хангамжийг худалдан авах ажиллагаа 2 удаа амжилтгүй болсон тохиолдолд” гэж шинээр тусгах; г. Тендерт оролцогчийн гаргасан гомдол үндэслэлгүй, тогтоогдоогүй бол эргээд гомдол гаргасан оролцогчийн тендерийн баталгааг улсын орлого болгохоос гадна тендерт оролцох эрхийг хасаж эрхээ хязгаарлуулсан этгээдийн хар жагсаалтад оруулах / 2. Цахим дэлгүүрээс 15 аж ахуйн нэгжийн 40 нэр төрлийн нэр төрлийн 89 багц хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээс 2 их сургууль, 11 цэцэрлэг, 55 ерөнхий боловсролын сургууль нийт 2,901,299,809.0 төгрөгийн үнэ бүхий 460774 ширхэг бүтээгдэхүүн худалдан авалт хийсэн байна. Худалдан авалтын дүнд 163,874,791 төгрөгийн хэмнэлтийг төсөвт бий болгосон байна. Хавсралт: 2 файл		80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
6	Хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах.	1. Дунд ахлах ангийн сурагчдад зориулсан “Fix my food” хөтөлбөр хэрэгжүүлэх 2. ЕБС-ийн үдийн хоолны чанар, шим тэжээлийн	-	1. Холбогдох судалгаа тооцоолол, төлөвлөгөөг гаргах 2. Арга хэмжээний хүрээнд ЕБС-ийн 45 сургуулийг хамруулсан сургалт,	1. БЕГ-ын даргын А/65 дугаар тушаалаар "Fix my food" арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэсэгт батлагдсан. Тус ажлын хэсгийн хүрээнд холбогдох мэдээлэл солилцон 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт санал тусгаж төлөвлөгөөг БЕГ-ын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2. “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийн хүрээнд ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй хоол тэжээлийн тусгай хэрэгцээтэй суралцагчдын хооллолтын байдлыг үнэлэх аргачлал бүхий гарын авлагын төслийн хэлэлцүүлгийг 2025.01.15-ны өдөр зохион байгуулав. Тус аргачлалыг тусгай хэрэгцээт суралцагчдын	3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ

		талаарх сургалт, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх		судалгаа зохион байгуулсан байна.	хооллолтыг дэмжих арга зүй, шим тэжээлийн үнэлгээ гэсэн үндсэн 2 хэсгээс бүрдэж байгаа бөгөөд ерөнхий боловсролын сургуульд ажиллаж буй багш, хоол зүйч, тогооч нар тусгай хэрэгцээт суралцагчдын хоолыг бэлтгэхээс эхлэн хооллож дуусах хүртэлх бүхий л үе шатанд хэрэглэх юм. Хэлэлцүүлгийг ЭМЯ, АШУҮИС, ШУТИС, ЖАЙКА, КОЙКА байгууллагын төслийн багууд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий цэцэрлэг, ЕБС, ТББ-ын төлөөлөл, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын эцэг эхийн төлөөлөл зэрэг холбогдох талууд оролцож холбогдох санал, сэтгэгдлээ илэрхийллээ. https://moe.gov.mn/post/163421 3. Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооноос зохион байгуулсан Хоршооны сургагч бэлтгэх сургалтад "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүнсний хангамж, хэрэгцээ" сэдвийн хүрээд хоршоологч нарт хүүхдийн хоолны хүнсний хангамжид тухайн бүс, орон нутагт үйлдвэрлэсэн чанар стандартын шаардлага хангасан, тогтвортой үнээр, тасралтгүй нийлүүлэх асуудлаар мэдээлэл хийж, санал солилцов. 4. Боловсролын сайдын "Арга хэмжээ зохион байгуулах, зардал батлах тухай" 2025 оны А/246 дугаар тушаалаар "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч нарт Монголын 5 өнгийн идээ ундааг ашиглан түүх соёл, өв уламжлал, ёс заншлыг таниулах "Уламжлалт сүү, цагаан идээ боловсруулах өдөрлөг"-ийг Лосолын лааган хүүхдийн хөгжил НҮТББ-тай хамтран 2025.05.30-ны өдөр зохион байгуулав. Хавсралт: 6 файл		төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
7	Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны нэгдсэн цэс төлөвлөлтийг	1. Өнгөний системтэй уялдсан тэнцвэртэй жишиг цэс бий болгох 2.	1. ----	1. Өнгөний системтэй уялдсан тэнцвэртэй жишиг цэс бий болгох 2. -	Боловсролын сайдын 2025 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн А/143 дугаар тушаалаар Жайка ОУБ-аас хамтран хэрэгжүүлж буй "Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол үйлдвэрлэлийг дэмжих төсөл"-ийн хүрээнд 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилтийг батлуулсан. Тус арга хэмжээний хүрээнд: 4 сарын 1-нд Өвөрхангай аймаг	2-р сар, 3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ:

	оновчтой зохион байгуулах туршилт судалгааны ажлыг зохион байгуулах	Тэнцвэртэй цэсийг зарим ЕБС-д туршин хэрэгжүүлж үр дүнг гаргах			дахь төслийн загвар сургуулиудын үйл ажиллагаа, хэрэгжилттэй танилцаж, аймаг, сумын хэмжээнд шим тэжээлийн тэнцвэртэй цэс төлөвлөх, шим тэжээлийн мэдээллийг өнгөний системээр илэрхийлэх арга зүй зэрэг орон нутгийн сайн жишээг аймгийн зэргэлдээх сумын сургуулиудад танилцуулах, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг, 4 сарын 18,19-нд Дундговь аймаг дахь төслийн загвар сургуулиудын үйл ажиллагаа болон аймгийн хэмжээнд, хүүхдийн шим тэжээл, эрдэс, амин дэмийг нөхөх тэнцвэртэй нөхөх зорилгоор хэрэгжүүлж буй Сүү хөтөлбөр, нэгдсэн жишиг цэсийн хэрэгжилтийн явцтай танилцаж, цэцэрлэг, сургуулийн тогооч нарын дунд ур чадварын тэмцээнийг зохион байгуулах замаар төслийн үр дүн болон сайн жишээг хөрш зэргэлдээх аймаг, сумдын бусад сургуулиудад түгээн дэлгэрүүлэх, туршлага судлах арга хэмжээг, 4 сарын 23-нд Өвөрхангай аймагт орон нутгийн сургуулийн Үдийн хоолны хүнсний хангамж, хоол үйлдвэрлэлийн орчин нөхцөл, хоол үйлдвэрлэлийн менежмент зэрэг асуудлаар төслийн үйл ажиллагаагаар дамжуулан олж авсан сайн жишээ, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх саналыг төр захиргааны байгууллага, төсөл хэрэгжүүлж буй байгууллагууд болон зэргэлдээх сум орон нутгийн сургуулиудад түгээн дэлгэрүүлэх, туршлага судлах арга хэмжээг тус тус зохион байгуулав. Дээрх арга хэмжээнд салбарын нийт 219 хүн хамрагдав. 4. Жишиг цэс нэвтрүүлэх ажлын хүрээнд Дундговь аймгийн хэмжээнд 18 сургууль, 22 цэцэрлэг, 17 дотуур байранд нэгдсэн журмаар жишиг цэсийг нэвтрүүлэн, 8900 суралцагчдад жишиг цэсийн дагуу хоолны үйлчилгээг үзүүлж байна. 5. Жайка ОУБ-ын төслийн ТУХ болон төлсийн хаалтын арга хэмжээг 2025.06.18-ны өдөр зохион байгуулав. Хавсралт: 8 файл		80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
8	Улсын хэмжээний	Судалгааны тайлан	-	Судалгаа авах мягтыг	1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүнсний хангамжийг сайжруулах ажлын хүрээнд 2024-	6-р сар, 9-р сар,	Өөрийн үнэлгээ:

	цэцэрлэг, сургуулийн хүнсний хангамжийн нэгдсэн судалгааг хийх			боловсруулж нийслэл, орон нутагт хүргүүлж, судалгааны арга зүйгээр ханган ажиллах	2025 оны хичээлийн жилд хэрэглэх хүнсний хангамжийн тооцоо, судалгааг аймаг, бүсийн хэмжээнд шинэчлэн гаргав. Тус хичээлийн жилд 1,057,324 суралцагчийн хүнсний түүхий эдийн хангамжид мах, махан бүтээгдэхүүн 12.6 мян. н, сүү, сүүн бүтээгдэхүүн 25.9 мян.тн, гурил, гурилан бүтээгдэхүүн 17.9 мян.тн, төрөл бүрийн будаа 6.2 мян.тн, төмс, хүнсний ногоо 27.0 мян.тн, жимс, жимсгэнэ 17.3 мян.тн тус тус хэрэглэх тооцоо гарсан. 2. Төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоолны хүнсний түүхий эд бүтээгдэхүүний худалдан авалтын талаарх мэдээлэл судалгааг дараах 2 үе шаттай зохион байгуулахаар ажиллаж байна. Үүнд : Хавсарлтад оруулсан загварын дагуу авахаар 21 аймгийн боловсролын газарт БЕГ-аар дамжуулан албан бичиг хүргүүлсэн. Тус албан бичгийн хүрээнд ирүүлсэн ААН-ийн мэдээлээллийг ХХААХҮЯ-нд хүргүүлж хамтран ажиллахаар шийдвэрлэсэн. Хавсралт: 2 файл	12-р сар	100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
--	--	--	--	---	--	----------	--

3.1. Салбарын урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнана.

9	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, салбарын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт,	Хэрэгжилтийн хувь	100	100	Хууль, тогтоол шийдвэрийн биелэлт, ЗГҮАХАХТ, Ерөнхий сайдын албан даалгавар зэрэг 25 баримт бичгийн 38 арга хэмжээний биелэлтийг цаг хугацаанд нь тайлагнасан. Жайка ОУБ-ын хүрээнд хэрэгжүүлж буй "Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төсөл"-ийн хүрээнд холбогдох тайлан, мэдээлэл, тодруулага өгч ажиллаж байна. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа
---	---	-------------------	-----	-----	---	---	---

	шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, цахим системд тайлагнах						гүйцэтгэсэн байдал: 100%
10	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын	Хэрэгжилтийн хувь	-	100	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хуулийн хүрээнд хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх							
---	--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Байгууллагаас зохион байгуулсан мэдээллийг цагт хамрагдаж мэдлэг ур чадвараа нэмэгдүүлсэн байна.	Төлөвлөсөн хугацаанд мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байна.	-	Хуваарийн дагуу сургалтад тогтмол хамрагдсан байна	Байгууллагын хэмжээнд зохион байгуулсан "Мэдээллийн цаг"-т тухай бүр хамрагдсан.	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%
2	Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлэх	Монгол бичгийн цахим сургалтад бие даан	-	-	Байгууллагаас зохион байгуулж буй Монгол бичгийн сургалтад	6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн

		суралцах			хамрагдаж байна.		даргын үнэлгээ: 100%
--	--	----------	--	--	------------------	--	-------------------------

ТАЙЛАН ГАРГАСАН:

Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, шим тэжээлийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Дондог
Оюун-Эрдэнэ /...../ Огноо: